



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 8/19

Жавхлант

**Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгчээр М.Шаравгавааг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 42 дугаар зүйлийн 42.1.9 дэх заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоолын хавсралт, Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2024 оны "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох тухай" 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журам 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, 2025 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 05/7798 дугаартай албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул Мөнхчулуун овогтой Шаравгавааг ажлын зайлшгүй шаардлагаар сонгон шалгаруулалт зарлагдаж, сул орон тоо нөхөгдөх хүртэлх хугацаанд Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Э.Хонгорзул

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд:

Э.Уугантуяа

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний мэргэжилтэн


Г.Батсайхан

Нярав

3. М.Шаравгавааг үндсэн цалинг 1 283 000 (нэг сая хоёр зуун наян гурван мянга) төгрөг, ажил хавсран гүйцэтгэгчийн 40 хувь, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах эрх бүхий албан тушаалтны 40 хувь, төрийн болон албаны нууц хамгаалах ажилтны 30 хувь, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндсэн цалингийн 2 хувь, орон нутгийн нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар тус тус тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАТЧУЛУУН



D:Zasag darga /zahiramj-2025/